



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/61/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Батжаргал

Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	966.8	5,175.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,338.8	15,163.1
	Нийт хөрөнгийн дүн	13,305.6	20,338.3
	Нийт өр төлбөрийн дүн	53.9	2,218.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,251.7	18,119.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,305.6	20,338.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	13,014.1	23,948.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	12,764.2	19,087.3
	Үйл ажиллагааны үр дүн	249.9	4,861.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	6.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	249.9	4,868.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,999.7	13,253.8
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(2.0)
	Тайлант оны үр дүн	249.8	4,868.0
	Эцсийн үлдэгдэл	13,249.5	18,119.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	11,671.3	15,599.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	11,671.3	15,596.0
	Үйл ажиллагааны ЦМГ	-	3.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
	Урсгал зардал	17,565.5	13,955.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	ЭМДС	16,945.9	11,950.7
	Улсын төсвөөс санхүүжих	-	1,384.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	619.8	619.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын эрхэм зорилгоо бид дэвшилтэт технологи, шинэ мэдлэгт суурилсан, ёс зүйтэй, сэтгэлд нийцсэн тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, үр дүнтэй, тэгш үзүүлнэ гэж тодорхойлсон байна. Тайлант онд гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцооны шинэ аргыг хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, E-Health программыг хөгжүүлж, цахимжуулалтыг сайжруулах, хандлага, харилцаа үр дүнг цалин урамшуулалтай холбон дүгнэх механизмыг бий болгох, байгууллагын маркетингийн бодлогыг хөгжүүлэх дэд зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 175 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 ширхэг нийт 736.2 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өглөг, авлагын барагдуулалтыг анхаарч үзнэ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 937.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 200.0 сая төгрөгийн алдааг залруулж, 736.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага бичиж, 0.8 сая төгрөгийн байшин, туслах аж ахуйтай холбоотой 2 зөвлөмж өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	937.0	1	200.0	-	-	1	736.2	2	0.8
	НИЙТ	4	937.0	1	200.0	-	-	1	736.2	2	0.8